



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

MONTHLY BULLETIN OF STATISTICS

2017/7



www.nso.mn govisumber.nso.mn www.1212.mn



ГАРЧИГ

- I. Нийгмийн байдал.....
- II. Нийгмийн даатгал, халамж.....
- III. Эрүүл мэнд
- IV. Гэмт хэрэг
- V. Үнэ.....
- VI. Төсөв.....
- VII. Хөдөө аж ахуй
- VIII. Аж үйлдвэр
- IX. Цаг уур.....
- Хавсралт.....



Говьсүмбэр аймгийн нийгэм, эдийн засгийн байдал



I. Нийгмийн байдал


I.1 Ажил хайгч иргэд

Тайлант сарын эцэст Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил хайгч иргэд 417, үүнээс ажил хайгч ажилгүй иргэдийн тоо 266 байгаагийн 149 нь эмэгтэйчүүд байна. Ажил хайгч ажилгүй иргэд өмнөх оны мөн үеэс 163 буюу 2.5 дахин өсч, өмнөх сараас 32 буюу 10.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Долоодугаар сард Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газарт 47 ажлын байрны захиалга иржээ.

Тайлант сард 33 иргэн ажилд зуучлагдсаны 19 буюу 57.6 хувь нь эмэгтэйчүүд байна. Ажилд зуучлуулсан иргэд өмнөх оны мөн үед байгаагүй болно.

Зураг I.1. Хөдөлмөр халамж, үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил хайгч иргэн, жил бүрийн тайлант сарын эцэст



Ажил хайгч ажилгүй иргэдийг насны бүлгээр нь авч үзвэл 15-24 насны 71, 25-34 насны 90, 35-44 насны 54, 45-54 насны 43, 55 түүнээс дээш насны 8 иргэн байна.

I.2 Ердийн хөдөлгөөн


Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2017 оны эхний 7 сарын байдлаар 196 эх амаржиж, 203 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс амаржсан эхийн тоо 66 буюу 25.2 хувиар, төрсөн хүүхдийн тоо 63 буюу 23.7 хувиар тус тус буурсан байна.

Нас баралт 66, бүртгүүлсэн гэр бүл 34, цуцалсан гэр бүл 16 байгаа нь өмнөх оны мөн үеэс цуцалсан гэр бүл 6 буюу 60.0 хувиар, нас баралт 3 буюу 24.5 хувиар өсч, бүртгүүлсэн гэр бүл 11 буюу 24.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд 2 хүүхэд үрчлэгдсэн. Шилжилт



хөдөлгөөний мэдээгээр 265 хүн шилжин ирж, 234 хүн шилжин явсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал шилжин ирэлт 43.1 хувиар, шилжин явалт 33.0 хувиар тус тус буурчээ.

Зураг 1.2.Төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн эхний 7 сарын байдлаар



II. Нийгмийн даатгал, халамж

II.1 Нийгмийн даатгал

2017 оны эхний 7 сарын байдлаар Эрүүл мэнд, нийгмийн даатгалын сангийн орлого 5111.2 сая төгрөг, зарлага 5846.2 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс орлого 1029.1 сая төгрөгөөр буюу 25.2 хувиар, зарлага 745.0 сая төгрөгөөр буюу 14.6 хувиар өссөн байна.

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөний биелэлт 115.7 хувьтай, зарлагын гүйцэтгэл 93.4 хувьтай байна.

II.2 Нийгмийн халамж

Нийгмийн халамжийн сангаас 2017 оны эхний 7 сарын байдлаар 3578 хүнд 856.9 сая төгрөгийн нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлсэн нь өмнөх оны мөн үеэс нийгмийн халамж хүртэгсэд 512 хүн буюу 12.5 хувиар буурч, олгосон тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж 68.8 сая төгрөг буюу 8.7 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

✓ Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид 2017 оны эхний 7 сарын байдлаар 922 хүн хамруулж 428.8 сая төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс 523 хүн буюу 36.2 хувиар, олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ 37.3 сая төгрөг буюу 8.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

✓ Нийгмийн халамжийн үйлчилгээ хөнгөлөлт, тусламжид 2017 оны эхний 7 сарын байдлаар 2656 хүн хамруулж 428.1 сая төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс 11 хүн буюу 0.4 хувиар, олгосон халамж үйлчилгээ, хөнгөлөлт, тусламж 106.5 сая төгрөг буюу 33.0 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.


II.3 Дундаж цалин

Аймгийн Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын хэлтсийн 2017 оны 7 дугаар сарын мэдээгээр 193 байгууллагын 5187 даатгуулагч иргэн, үүнээс 638 нь сайн дурын даатгуулагч байна. Ажиллагсдын дундаж цалинг аж ахуйн нэгж байгууллагын хариуцлагын хэлбэрээр авч үзвэл



төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой 11 аж ахуйн нэгж, байгууллагын 362 ажилтны дундаж цалин 754.1 мянган төгрөг, төсөвт 55 байгууллагын 1635 ажилтны дундаж цалин 661.1 мянган төгрөг, 2 Хувьцаат Компаний 646 ажилтны дундаж цалин 1191.5 мянган төгрөг, 108 ХХКомпаний 1743 ажилтны дундаж цалин 763.7 мянган төгрөг, бусад 17 аж ахуйн нэгж байгууллагын 163 ажилтны дундаж цалин 358.4 мянган төгрөг боллоо.

Зураг II.1.Нийгмийн даатгалын даатгуулагчийн тоо, 2017 оны эхний 7 сарын байдлаар




III.Эрүүл мэнд



Эрүүл мэндийн газраас эрхлэн гаргадаг мэдээгээр 2017 оны эхний 7 сарын байдлаар 233 эх амаржиж, 2016 оны мөн үетэй харьцуулахад 47 буюу 16.8 хувиар буурсан байна. Амьд төрсөн хүүхэд 233 үүнээс 123 нь хүү, 110 нь охин байна. Өмнөх оны мөн үеэс амьд төрсөн хүүхэд 48 буюу 17.1 хувиар буурсан байна.

0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 2, 1-5 хүртэл насны хүүхдийн эндэгдэл 3 бүртгэгдсэн байна. Эхийн эндэгдэл бүртгэгдээгүй.


Зураг III.1. Амаржсан эх, амьд төрсөн хүүхэд, жил бүрийн эхний 7 сарын байдлаар





Халдварт өвчин эхний 7 сарын байдлаар 113 буюу 10000 хүн амд 67.8 хүн байгаа нь өмнөх оны мөн үеэс 111 тохиолдлоор буурчээ.


Зураг III.2.Нас баралт, жил бүрийн эхний 7 сарын байдлаар



Он гарсаар давхардсан тоогоор 62298 хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 13162 хүнээр буюу 17.4 хувиар, 2862 өвчтөн эмчлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 135 хүнээр буюу 4.5 хувиар буурсан байна.

2017 оны эхний 7 сарын байдлаар түргэн тусламжийн дуудлага 3843, халдварт өвчин 113 бүртгэгдсэн байна.

Зураг III.3.Амьгүй төрсөн хүүхэд болон нялхасын эндэгдэл, жил бүрийн эхний 7 сарын байдлаар






IV. Гэмт хэрэг

Аймгийн Цагдаагийн хэлтсийн мэдээгээр 2017 оны эхний 7 сарын байдлаар 105 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 24 буюу 18.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Зураг IV.1.Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, жил бүрийн эхний 7 сарын байдлаар




Өмнөх оны мөн үеэс нийт гэмт хэргийн тоо буурахад өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг болон хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг тодорхой хэмжээгээр буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Илрээгүй гэмт хэрэг 22 байгаа нь өмнөх оны мөн үеэс 22.2 хувиар өссөн. Гэмт хэрэг илрүүлэлтийн хувь 55.0 болсон нь өмнөх оны мөн үеэс 17 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

Гэмт хэргийн улмаас 70 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үеэс 14.6 хувиар буурсан байна.

Зураг IV.2.Гэмт хэргийн ангилал, жил бүрийн эхний 7 сарын байдлаар




Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2017 оны эхний 7 сарын байдлаар 209.0 сая төг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 154.0 сая төг болж, өмнөх оны мөн үеэс учирсан хохирлын хэмжээ 70.0 сая төгрөгөөр буюу 25.1 хувиар, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 36.0 сая төгрөг буюу 18.9 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

2017 оны эхний 7 сарын байдлаар давхардсан тоогоор 395 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 148 хүнээр буюу 27.4 хувиар буурсан байна.



Зураг IV.3. Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо жил бүрийн эхний 7 сарын байдлаар



V. Хэрэглээний үнийн индекс

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрлөөр өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ аймгийн хэмжээнд 2017 оны 7 дугаар сард өмнөх оны мөн үеэс 3.8 хувиар, 2016 оны жилийн эцсээс 3.4 хувиар өсч, өмнөх сараас 0.1 хувиар буурсан байна.

Хүснэгт V.1. Хэрэглээний үнийн индекс, 2017 оны 7 дугаар сард, бүлгийн дүнгээр

Бараа үйлчилгээний бүлэг	2017. VII	2017. VII	2017. VII
	2016. VII	2016. XII	2017. VI
Ерөнхий индекс	103.8	103.4	99.9
Хүнсний бараа, ундаа, ус	101.1	105.9	98.4
Согтууруулах ундаа, тамхи	104.0	103.6	100.0
Хувцас, бөс бараа, гутал	107.6	102.4	100.6
Орон сууц, ус, цахилгаан, түлш	104.2	99.2	100.4
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	100.3	101.4	101.1
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	101.4	100.8	100.0
Тээвэр	109.0	109.2	99.8
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	100.0	100.0	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	99.6	99.7	99.7
Боловсролын үйлчилгээ	99.9	99.9	99.9
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байр	100.2	100.0	100.0
Бусад бараа, үйлчилгээ	103.3	103.3	102.1

Эх үүсвэр: Үндэсний статистикийн хорооны сарын мэдээ


**VI. Төсөв санхүү**

2017 оны эхний 7 сарын байдлаар орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө 8439.9 сая төгрөг, гүйцэтгэлээр 8439.9 сая төгрөг болж 100.0 хувийн биелэлттэй байна.

Аймгийн төсвийн нийт зарлагын төлөвлөгөө 10 778.8 сая төгрөг, гүйцэтгэлээр 7749.2 сая төгрөг болж 71.9 хувийн гүйцэтгэлтэй байна.


2017 оны эхний 7 сарын байдлаар авлагын үлдэгдэл 14.3 сая төгрөг, өглөгийн үлдэгдэл 78.4 сая төгрөг байна.

Зураг VI.1.Орон нутгийн төсвийн орлого, зарлага, жил бүрийн эхний 7 сарын байдлаар, сая төгрөгөөр

**VII. Мал аж ахуй, газар тариалан**


Аймгийн хэмжээнд 2016 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 185558 хээлтэгч малын 140897 буюу 75.9 хувь нь төллөсөн байна. Төл бойжилт 99.0 хувьтай байна. 2017 оны эхний 7 сарын байдлаар 2170 толгой том мал зүй бусаар хорогдсон нь өмнөх оны мөн үеэс 5.3 дахин бага байна. Том малын зүй бус хорогдлын 19.4 хувь нь хээлтэгч мал байна.

Зураг VII.1.Төллөсөн хээлтэгч, жил бүрийн эхний 7 сарын байдлаар, толгойгоор






Зураг VII.2.Хорогдсон хээлтэгч, жил бүрийн эхний 7 сарын байдлаар, толгойгоор



2017 онд аймгийн хэмжээнд нийт 38.7 га талбайд төмс, хүнсний ногоо, тэжээлийн ургамал тариалсан байна. Тариалсан талбайн мэдээг өмнөх оны мөн үетэй харьцуулбал төмс 5.7 га талбайгаар буюу 24.9 хувиар, хүнсний ногоо 1.0 га талбайгаар буюу 5.4 хувиар, тэжээлийн ургамал 5.9 га талбайгаар буюу 2.4 дахин буурсан байна.

Зураг VII.3.Тариалсан талбай, 2017 оны байдлаар, га




VIII. Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2017 оны эхний 7 сарын байдлаар 25.6 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.7 тэрбум төгрөг буюу 7.1 хувиар, оны үнээр 26.4 тэрбум төгрөгийн борлуулалт хийгдсэн нь өмнөх оны мөн үеэс 3.9 тэрбум төгрөг буюу 16.9 хувиар өслөө.

Шивээ-Овоо ХК нийт бүтээгдэхүүний 90.1 хувь буюу 23.2 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийт борлуулалтын 91.3 хувь буюу 24.1 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан байна.



Зураг VIII.1. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, салбараар, жил бүрийн эхний 7 сарын байдлаар, сая төгрөгөөр



IX. Цаг агаарын мэдээ 7 дугаар сард:

Хур тунадас: Энэ сард нийт 30.1 мм хур тунадас орсон байна.


Салхи: Ихэнх хугацаанд 5 -10 м/сек, зарим үед 12 м/сек хүрч салхилсан.

Агаарын температур: Дунджаар 22.6 хэм дулаан, хамгийн ихдээ 39.3 хэм дулаан байлаа.


2017 оны 8 дугаар сарын ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВ

Уур амьсгалын дунджаар агаарын температурын сарын дундаж 20-25 хэм дулаан байх бөгөөд олон жилийн дунджаас 1.0-1.5 хэмээр дулаан байх төлөвтэй.

Говьсүмбэр аймгийн нутгаар энэ сард орох хур тунадас нь уур амьсгалын дунджаас бага бороо орох төлөвтэй. Нэгдүгээр арав хоногийн дунд болон сүүлч, хоёрдугаар ба гуравдугаар арав хоногийн эхэн болон сүүлчээр түр зуурын бороо, хоёрдугаар арав хоногийн дунд үеэр түр зуурын бороо орно. Дуу цахилгаантай. Салхи борооны өмнө зарим газраар түр зуур ширүүснэ.



1 дүгээр зураг. 2 дугаар сарын агаарын температурын уур амьсгалын дундаж (°C)



3 дугаар зураг. 2 дугаар сард ордог хур тунадасны уур амьсгалын дундаж (мм)



ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 7 сарын байдлаар

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2016 I-VII	2017 I-VII	$\frac{2017 \text{ I} - \text{VII}}{2016 \text{ I} - \text{VII}} \%$
Нийгмийн статистик				
Амьд төрсөн хүүхэд	хүүхэд	281	233	82.9
Ажил хайгч ажилгүй иргэд, сарын эцэст	хүн	103	266	258.3
Халдварт өвчнөөр өвчлөгсөд	хүн	224	113	50.4
Бүртгэгдсэн гэмт хэрэг	хүн	129	105	81.4
Эдийн засгийн статистик				
Орон нутгийн төсвийн орлого	сая.төг	9110.8	8439.9	92.6
Орон нутгийн төсвийн зарлага	сая.төг	7912.3	7749.2	97.9
Авлага	сая.төг	19.3	14.3	74.1
Өглөг	сая.төг	553.2	78.4	14.2
Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт	сая.төг	23915.3	25603.7	107.1
Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн борлуулалт	сая.төг	22537.5	26375.5	105.0
Төллөсөн хээлтэгч	толгой	150604	140897	93.6
Гарсан төл	толгой	151790	141710	93.4
Хорогдсон төл	толгой	3335	1370	41.1
Бойжсон төл	толгой	148455	140340	94.5
Том малын зүй бусын хорогдол	толгой	11419	2170	19.0



I.1 АЖЛЫН БАЙРНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн 7 сарын байдлаар

Үзүүлэлтүүд	2016 I-VII	2017 I-VII	$\frac{2017 I - VII}{2016 I - VII} \%$
Ажил хайгч иргэд, сарын эцэст	174	417	388.1
Үүнээс: эмэгтэй	100	236	236.0
Ажил хайгч ажилгүй иргэд, сарын эцэст	103	266	258.2
Үүнээс: эмэгтэй	58	149	256.9
Ажлын байрны захиалга	0	47	*
Ажилд зуучлагдсан иргэд	0	33	*
Үүнээс: эмэгтэй	0	19	*

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэдээ

I.2 ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 7 сарын байдлаар

Үзүүлэлтүүд	2016 I-VII	2017 I-VII	$\frac{2017 I - VII}{2016 I - VII} \%$
Амаржсан эх	262	196	74.8
Төрсөн хүүхэд	266	203	76.3
Үрчлэгдсэн хүүхэд	3	2	66.7
Бүртгүүлсэн гэр бүл	45	34	75.6
Цуцалсан гэр бүл	10	16	160.0
Нас баралт	63	66	104.8
Шилжин ирсэн	466	265	56.9
Шилжин явсан	349	234	67.0

Эх үүсвэр: Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээ

II.1 ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, жил бүрийн эхний 7 сарын байдлаар

Сангийн төрөл	2016 I-VII	2017 I-VII	$\frac{2017 I - VII}{2016 I - VII} \%$
ЭМНД-ын сангийн орлого, сая.төг	4 082.1	5 111.2	125.2
ЭМНД-ын сангийн зарлага, сая.төг	5 101.2	5 846.2	114.6

Эх үүсвэр: Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн мэдээ



II.2 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮН, ОЛГОСОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, жил бүрийн эхний 7 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2016 I-VII		2017 I-VII		$\frac{2017 \text{ I} - \text{VII}}{2016 \text{ I} - \text{VII}} \%$	
	Хүн	Мөнгөн дүн	Хүн	Мөнгөн дүн	Хүн	Мөнгөн дүн
Нийгмийн халамжийн сангийн дүн	4 090	788.1	3 578	856.9	87.5	108.7
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	1 445	466.1	922	428.8	63.8	92.0
Халамжийн тэтгэвэр	348	223.2	260	223.9	74.7	100.3
Нөхцөлт мөнгөн тэтгэмж	1 097	242.9	662	204.9	60.3	84.4
Нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлт тусламж	2 645	322.0	2 656	428.1	100.4	133.0
Ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	565	40.1	722	138.5	127.8	345.4
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	202	40.6	91	17.3	45.0	42.6
Нийгмийн халамжийн үйлчилгээ	378	27.2	379	23.8	100.3	87.5
Нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт тусламж мөнгөн тусламж	322	47.2	250	80.1	77.6	169.7
Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	7	7.2	5	5.8	71.4	80.6
Алдарт эхийн одонтой эхчүүдэд үзүүлэх мөнгөн тусламж	1 171	159.7	1 209	162.6	103.2	101.8

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэдээ



III.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 7 сарын байдлаар

Үзүүлэлт	2016 I-VII	2017 I-VII	$\frac{2017 I - VII}{2016 I - VII} \%$
Төрсөн эх	280	233	83.2
Амьд төрсөн хүүхэд	281	233	82.9
Эрэгтэй	136	123	90.4
Эмэгтэй	145	110	75.9
Амьгүй төрсөн хүүхэд	2	1	50.0
Нийт нас баралт	43	51	118.6
Эмнэлгийн нас баралт	10	5	50.0
Хоног болоогүй нас баралт	6	5	66.7
0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	6	2	33.3
1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	2	3	150.0
Эмчлэгдсэн өвчтөн	2 997	2 862	95.5
Амбулаторийн үзлэг	75 460	62 298	82.6
Халдварт өвчин	224	113	50.4

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газрын мэдээ

IV.1 ЭРҮҮГИЙН БОЛОН ХЭВ ЖУРМЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН МЭДЭЭ , жил бүрийн эхний 7 сарын байдлаар, төрлөөр

Үзүүлэлт	2016 I-VII	2017 I-VII	$\frac{2017 I - VII}{2016 I - VII} \%$
Бүртгэгдсэн гэмт хэрэг	129	105	81.4
Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг	61	53	86.9
Өмчлөх эрхийн эсрэг	42	32	76.2
Нийгмийн аюулгүй байдлын эсрэг	5	3	60.0
Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	7	12	171.4
Хүүхэд гэр бүлийн нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг	4	3	75.0
Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	5	1	20.0
Бусад гэмт хэрэг	5	1	20.0



Гэмт хэрэгт <u>холбогдог</u> сод	131	115	87.8
15 хүртэлх насны	1	2	200.0
16-34 насны	96	70	72.9
35 ба түүнээс дээш насны	34	43	126.5
Боловсрол – Дээд	20	20	100.0
Боловсрол - Тусгай дунд	16	6	37.5
Боловсрол – Бүрэн дунд	49	35	71.4
Боловсрол – Бүрэн бус дунд	27	30	111.1
Боловсрол – Бага	13	7	53.8
Боловсролгүй	6	17	283.3
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдсэн	4	9	225.0
Ажилгүй иргэд үйлдсэн	61	51	83.6
Эмэгтэй хүн оролцсон	21	16	76.2
Хүүхэд оролцсон	6	10	166.6
Бүлгээр үйлдсэн	17	7	41.2
Согтуугаар үйлдсэн	47	36	76.6
Гэмт хэргийн гаралт, нөхцөл байдал	129	105	81.4
Гудамж талбайд	36	27	75.0
Гэмт хэргийн улмаас нас барсан	4	8	200.0
Гэмт хэргийн улмаас гэмтсэн	82	70	85.4
Учирсан хохирол / сая.төг /	279.0	209.0	74.9
Нөхөн төлүүлсэн хохирол / сая.төг /	190.0	154.0	81.1

Эх үүсвэр: Цагдаагийн хэлтсийн мэдээ

VI.1 ТӨСВИЙН ОРЛОГО, үзүүлэлтүүдээр, жил бүрийн эхний 7 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2016 I-VII	2017 I-VII	$\frac{2017 I - VII}{2016 I - VII} \%$
Нийт орлого	9 110.8	8 439.9	92.6
Урсгал орлого	3 223.1	3 417.9	106.0
Татварын орлого	2 977.9	2 593.1	87.1
Татварын бус орлого	245.2	824.7	336.3
Тусламжийн орлого	5 887.7	5 022.0	85.3

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээ



VI.2 ТӨСВИЙН ЗАРЛАГА, үзүүлэлтүүдээр, жил бүрийн эхний 7 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2016 I-VII	2017 I-VII	$\frac{2017 I - VII}{2016 I - VII} \%$
Нийт зарлага	7 912.3	7 749.2	97.9
Урсгал зардал	6 892.7	7 260.1	105.3
Хөрөнгийн зардал	1 019.6	489.1	48.0

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээ

VI.3 ТӨСВИЙН ӨГЛӨГ, АВЛАГЫН ҮЛДЭГДЭЛ, үзүүлэлтүүдээр, жил бүрийн эхний 7 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2016 I-VII	2017 I-VII	$\frac{2017 I - VII}{2016 I - VII} \%$
Авлага	19.3	14.3	74.1
Өглөг	553.2	78.4	14.2
Төсөвт байгууллагын тоо	45	49	106.5
Төсөвт байгууллагын ажиллагсад	769	783	101.8

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээ

VII.1 МАЛ ТӨЛЛӨЛТ, эх малын төрлөөр, жил бүрийн эхний 7 сарын байдлаар

Төрөл	2016 I-VII	2017 I-VII	$\frac{2017 I - VII}{2016 I - VII} \%$
Бүгд	150 604	140 897	93.6
Ингэ	193	120	62.2
Гүү	3 833	4 022	104.9
Үнээ	3 861	3 687	95.5
Эм хонь	73 019	69 113	94.7
Эм ямаа	69 698	63 955	91.8

VII.2 ТӨЛЛӨСӨН ХЭЭЛТЭГЧ сумдаар, жил бүрийн эхний 7 сарын байдлаар

Сумд	2016 I-VII	2017 I-VII	$\frac{2017 I - VII}{2016 I - VII} \%$
Дүн	150 604	140 897	93.6
<u>Баянтал</u>	23 933	21 659	90.5
Сүмбэр	111 712	102 074	91.4
<u>Шивээговь</u>	14 959	17 164	114.7



VII.3 БОЙЖСОН ТӨЛ, төлийн төрлөөр, жил бүрийн эхний 7 сарын байдлаар

Төрөл	2016 I-VII	2017 I-VII	$\frac{2017 I - VII}{2016 I - VII} \%$
Бүгд	148 455	140 340	94.5
Ботго	181	116	64.1
Унага	3 782	4 005	105.9
Тугал	3 719	3 659	98.4
Хурга	72 249	68 838	95.3
Ишиг	68 524	63 722	93.0

VII.4 БОЙЖСОН ТӨЛ, сумдаар, жил бүрийн эхний 7 сарын байдлаар

Сумд	2016 I-VII	2017 I-VII	$\frac{2017 I - VII}{2016 I - VII} \%$
Дүн	148 455	140 340	94.5
<u>Баянтал</u>	23 786	21 789	91.6
Сүмбэр	109 979	101 333	92.1
<u>Шивээговь</u>	14 690	17 218	117.2

VII.5 ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН ТОМ МАЛ, малын төрлөөр, жил бүрийн эхний 7 сарын байдлаар

Төрөл	2016 I-VII	2017 I-VII	$\frac{2017 I - VII}{2016 I - VII} \%$
Бүгд	11 419	2 170	19.0
Тэмээ	1	3	300.0
Адуу	304	29	9.5
Үхэр	473	105	22.2
Хонь	4 040	803	19.9
Ямаа	6 601	1 230	18.6

VII.6 ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН ТОМ МАЛ, сумдаар, жил бүрийн эхний 7 сарын байдлаар

Сумд	2016 I-VII	2017 I-VII	$\frac{2017 I - VII}{2016 I - VII} \%$
Дүн	11 419	2 170	19.0
<u>Баянтал</u>	1 981	260	13.1
Сүмбэр	6 490	1 827	28.2
<u>Шивээговь</u>	2 948	83	2.8



VII.7 ХОРОГДСОН ХЭЭЛТЭГЧ МАЛ, малын төрлөөр, жил бүрийн эхний 7 сарын байдлаар

Төрөл	2016 I-VII	2017 I-VII	$\frac{2017 I - VII}{2016 I - VII} \%$
Бүгд	3 612	429	11.7
Тэмээ	0	0	*
Адуу	213	7	3.3
Үхэр	167	27	16.2
Хонь	1 381	208	15.1
Ямаа	1 851	187	10.1

VII.8 ХОРОГДСОН ХЭЭЛТЭГЧ МАЛ, сумдаар, жил бүрийн эхний 7 сарын байдлаар

Сумд	2016 I-VII	2017 I-VII	$\frac{2017 I - VII}{2016 I - VII} \%$
Дүн	3 612	429	11.7
Баянтал	158	31	19.6
Сүмбэр	695	377	54.2
Шивээговь	2 759	21	0.8

VIII.1 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт жил бүрийн эхний 7 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2016 I-VII	2017 I-VII	$\frac{2017 I - VII}{2016 I - VII} \%$
Нийт	23 915.3	25 603.7	107.1
Нүүрс	22 775.9	23 199.5	101.9
Дулаан	935.0	1 037.0	110.9
Цэвэр ус	98.5	186.9	189.7
Сувагжуулалт	36.7	75.8	206.5
Бусад	69.2	1 104.5	1 596.1

VIII.2 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт, жил бүрийн эхний 7 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2016 I-VII	2017 I-VII	$\frac{2017 I - VII}{2016 I - VII} \%$
Нийт	22 537.5	26 375.5	117.0
Нүүрс	21 368.5	24 161.8	113.1
Дулаан	1 066.1	1 213.0	113.8
Усан хангамж, ус ариутгал	4.1	3.7	90.2
Бусад	98.8	997.0	1 009.1



VIII.3 Уул уурхайн салбарын бүтээгдэхүүний үзүүлэлтүүд, Шивээ-Овоо ХК жил бүрийн эхний 7 сарын байдлаар

Үзүүлэлт	2016 I-VII	2017 I-VII	$\frac{2017 \text{ I} - \text{VII}}{2016 \text{ I} - \text{VII}} \%$
Нүүрс борлуулалт /үнийн дүнгээр, сая.төг/	21 368.5	24 161.8	113.1
Нүүрс гаргалт /үнийн дүнгээр, сая.төг/	22 775.9	23 199.5	101.9
Нүүрс гаргалт /биет хэмжээ, мян.тн/ Ажиллагсад	990.1 595	1 026.7 553	103.7 92.9

Е-майл хаяг:

govisumber@nso.mn

Вэб хаяг:

govisumber.nso.mn

Мэдээллийн сангийн хаяг:

www.1212.mn

Утас:

70543222, 70543017